



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/259

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 50/1671 дугаар албан бичгийн дагуу Хөвсгөл аймгийн хэмжээнд сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчилд криминологи судалгаа хийлгэсэн зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 10,000,000 (арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3 Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ